

“ТЭЖЭЭЛ”ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

Нийслэлийн малын тоо 385 мянга болж, жилд 50 гаруй мянган толгой малаар өссөнтэй уялдуулан нийслэлийн мал аж ахуйн салбар, хүн амын суурьшил ,өсөлттэй уялдуулан нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн зах зээлийн нөхцөлд өрсөлдөх чадвартай ,эдийн засгийн үр ашигтай салбар байх нөхцлийг бүрдүүлж , нийслэлийн хүн амыг эрүүл, аюулгүй экологийн цэвэр хүнсээр хангах явдал чухал болоод байна.

Нийслэлд мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлж эрчимжсэн мах, сүүний үхрийн аж ахуй, гахай, тахианы аж ахуйг тусгай жороор бэлтгэсэн бүрэн найрлагат тэжээлээр хангаж, тэдгээрийн биологийн нөөцийг бүрэн дүүрэн ашиглах нь чухал асуудлын нэг юм.

Иймээс нийслэлийн мал аж ахуйн салбарын хөгжилд уялдсан тэдгээрийг шийдвэрлэх талаарх асуудлыг тусгасан “Малын тэжээл “дэд хөтөлбөрийг танилцуулж байна.

Мал аж ахуйн салбарын тулгамдсан асуудлын нэг болох малын тэжээлийн асуудлыг үндэсний болон, дэд хөтөлбөр, бусад баримт бичгүүдэд тусгасан байдаг боловч уг асуудал нь эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаа аж ахуй нэгжүүд, фермер эрхлэгчдийн хамгийн тулгамдсан асуудлуудын нэг болсоор байна.

Иймээс нийслэлийн эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, технологийн дагуу бэлтгэсэн бүрэн орц, найрлагатай тэжээлээр зах зээлийг хангах нь чухал юм.

Уг хөтөлбөр хэрэгжснээр эрчимжсэн мал аж ахуйгаас авах ашиг шим, бүтээгдхүүний гарц нэмэгдэж, нийслэлийн хүн амыг эрүүл, экологийн цэвэр хүнсний бүтээгдхүүнээр хангах боломж бүрдэх төдийгүй тэжээлийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих чиглэлээр төрөөс дэмжлэг үзүүлэх нөхцөл боломжоор хангах , эрчимжсэн мал аж ахуйд тохирсон тэжээлийн асуудлыг шийдвэрлэх бүрэн боломжтой болно.